



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 4/06.

Чингис хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Ахмадын сангийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн батлагдсан төсвийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүрийнхээ төсөвт тусган батлуулж, тус санд шилжүүлж байхыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2021 оны 01. дугаар сарын 27. өдрийн
406 дугаар тушаалын хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Ахмад настны тухай хуулийн 14.7, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам”-ын 1.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн Засаг даргын Тамгын газар, Ахмадын сан /цаашид “сан” гэх/-г байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд тусламж, дэмжлэг үзүүлэхэд сангийн зорилго оршино.

1.3 Аймгийн Засаг даргын Тамгын газар нь тухайн жилд батлагдсан төсвийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг санд төвлөрүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана.

1.4 Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сангийн зөвлөл хамтран хариуцаж гүйцэтгэнэ.

1.5 Сангийн хөрөнгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн зарцуулна.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журамд Аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ахмадын зөвлөлд албан ёсны бүртгэлтэй ахмадууд хамрагдана.

ГУРАВ. Сангийн хөрөнгө бүрдүүлэлт

3.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

3.1.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар тухайн жилийн батлагдсан төсвөөс цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө;

3.1.2. Сангийн үйл ажиллагаанаас олох орлого;

3.1.3. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;

3.1.4. Гадаад, дотоодын байгууллага болон иргэд, байгууллагаас санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж;

3.1.5. Бусад эх үүсвэр


ДӨРӨВ. Сангийн хөрөнгийн зарцуулалт

4.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам”-ын 3.1-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна.

4.1.1. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах, дүү, терөл садангүй, ганц бие ахмад настанд хөдөлмөрийн хөлслний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг жилд 1 удаа олгох;

4.1.2. Ахмад настан өөрөө, эсхүл түүний нөхөр /эхнэр/ нь нас барсан тохиолдолд 50000 /таван зуун мянган/ төгрөгийн мөнгөн тусламж олгох;

4.1.3 Ахмад настан өөрөө хүндээр өвдөж, удаан хугацаагаар эмчлүүлэхэд



мөнгөн дэмжпэг олгох;

4.1.4. Сар шинийн баяр, ахмадын өдрийг тохиолдуулан Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, удирдлага, хамт олноос ахмад настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх;

4.1.5. Ахмад настны насын ой болон хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх арга хэмжээнд хүндэтгэл үзүүлэх;

4.1.6. Ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

4.1.7. Шинээр хашаа байшин барих, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд 1 удаа дэмжлэг үзүүлэх

4.1.8. Хууль, журамд заасан бусад зүйлд;

4.2. Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно.

4.3. Сангаас дэмжлэг, тусламж авахыг хүссэн ахмад настан оршин суугаа баг, хорооны Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга байна. Бурдүүлэн байгууллагын дэргэдэх Сангийн зөвлөлд бичгээр хүсэлт гаргана.

ТАВ. Сангийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Ахмадын сангаас хөрөнгө зарцуулах тухай санал боловсруулах Сангийн зөвлөл байна.

5.2. Сангийн зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба Зөвлөлийн дарга нь Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга байна. Сангийн зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газраас 3 /Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, нийгмийн бодлогын хэлтсийн ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн/

- Ахмадын зөвлөлөөс 2 /Ахмадын зөвлөлийн дарга, ахмад настны төлөөлөл/

5.3. Сангийн зөвлөл нь энэхүү журмын 4.1-д заасан асуудлыг хэлэлцэн хуралдаж, албан ёсны санал боловсруулна.

5.4. Зөвлөлийн саналыг үндэслэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга шийдвэрлэнэ.

5.5. Зөвлөлийн хурлын явцын тэмдэглэлийг Нийгмийн бодлогын хэлтсийн ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн хөтөлж, албажуулна.

5.6. Зөвлөлийн хурлын тэмдэглэлд Зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулна.

5.7. Ахмадын сан нь Төрийн санд данстай байна.

ЗУРГАА. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

6.1. Сангийн хөрөнгийн бурдүүлэлт, зарцуулалтад байгууллагын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

6.2. Сангийн зөвлөл нь үйл ажиллагааны тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор багтаан Аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлага, байгууллагын дэргэдэх Ахмадын зөвлөлд танилцуулж, тайлagnana.